

Улсын нэгдсэн бүртгэлийн 2014. оны 11. 23-ны
дугаарт бүртгэв.
Монгол Улсын Хамтарсан тушаалынам 79

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛЫН АМАСНЯГИЙН ДАЛГААРЫН 10 ДУГААР

2014 оны 10 дугаар
сарын 24 -ны өдөр

дугаар 356 / A/182

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

- “Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
- Энэ журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа), Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Баярцэцэг), Тахарын ерөнхий газрын дарга (Ц.Азбаяр) нарт даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

ХУУЛЬ ЗҮЙН САЙД

Н.УДВАЛ

Х.ТЭМҮҮЖИН



ГЭРЧ, ХОХИРОГЧИД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу гэмт хөргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон, хамгаалалтанд байгаа гэрч, хохирогчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хамгаалалтанд байгаа гэрч, хохирогчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай, Эрүүл мэндийн тухай, Тахарын албаны тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд баримтлах удирдамж, стандарт болон энэ журмыг баримтална.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Гэрч, хохирогч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасан байгууллага /цаашид “эрх бүхий байгууллага” гэх/ бүрдүүлэх бөгөөд бүх шатны эрүүл мэндийн байгууллага өмчийн хэлбэрээс үл хамааран гэрч, хохирогчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

2.2. Гэрч, хохирогчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн талаарх нэгдсэн мэдээллийг Эрүүл мэндийн хөгжлийн төв жил бүр Тахарын ерөнхий газрын хамгаалалтын нэгжид хүргүүлнэ. Хамгаалалтын нэгж нь гэрч, хохирогчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгдсэн бүртгэл хөтөлж, байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа болон бусад шаардлагатай арга хэмжээг төлөвлөхөд ашиглана.

2.3. Гэрч, хохирогчийг эрүүл мэндийн байгууллагад хэвтүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тохиолдолд түүний аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг хамгаалалтанд авсан байгууллага хариуцна. Хамгаалалт зохион байгуулахад шаардагдах хүн хүч, техник хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд Тахарын албанаас дэмжлэг авч болно.

2.4. Эрүүл мэндийн байгууллагын удирдлага энэ журмын 2.3 дах хэсэгт заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, шаардлагыг хангасан өрөө, тасалгааг тусгайлан гаргаж үйлчилнэ.

2.5. Эрх бүхий байгууллага нь төрөлжсөн мэргэжлийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ шаардлагатай гэрч, хохирогчийг анх хүлээн авсан эрүүл мэндийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн зохих эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авна.

Гурав. Гэрч, хохирогчийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах

3.1. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.5 дахь хэсэгт заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан гэрч, хохирогч гэмт хэргийн улмаас эрүүл мэндэд нь хохирол учирснаас бусад тохиолдолд эрх бүхий байгууллагад мэдэгдэж, ердийн журмаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдана.

3.2. Хамгаалалтанд авсан эрх бүхий байгууллага нь энэ журмын 3.1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд гэрч, хохирогчийг эрүүл мэндийн байгууллагад хүргэх, тусламж, үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.

3.3. Энэ журмын 2.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн байгууллага нь хамгаалалтын албан хаагчийн анхны шаардлагаар гэрч, хохирогчийг аливаа баримт бичиг шаардахгүйгээр шууд хүлээн авч, дараалал харгалзахгүйгээр шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлнэ.

3.4. Гэрч, хохирогчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь гэрч, хохирогчид үзүүлсэн тусламж, үйлчилгээ, түүний хувийн мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

3.5. Гэрч, хохирогч ердийн журмаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдахаас бусад тохиолдолд түүний нэр, хаяг, утасны дугаар нууц байх бөгөөд хүргэж ирсэн албан хаагчийн өгсөн мэдээллийн дагуу бүртгэнэ.

3.6. Хамгаалалтанд авсан эрх бүхий байгууллагын дуудлагын дагуу томилогдсон эмнэлгийн мэргэжилтэн гэрч, хохирогчийн байрлаж буй газар очиж анхан шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ. Гэрч, хохирогч аюулгүй газарт буюу хамгаалах байранд байгаа тохиолдолд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн мэргэжилтнийг уг газарт авчрах, буцаан хүргэх ажиллагаа болон хамгаалах байрны байршил, хүрэх замын чиглэлийн нууцлалыг хамгаалалтанд авсан байгууллага хариуцна.

3.7. Гэрч, хохирогч амь насанд нь аюултайгаас бусад тохиолдолд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахаас татгалзсан тохиолдолд түүнд албадлага хэрэглэхээс зайлсхийх бөгөөд энэ тухай тэмдэглэл хөтөлж, хувийн хэрэгт хавсаргана.

3.8. Эрх бүхий байгууллага нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдах явцад гэрч, хохирогчид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх шаардлага гарсан тохиолдолд Тахарын ерөнхий газрын хамгаалалтын нэгжээс туслалцаа авна. Хамгаалалтын тусгай нэгж нь сэтгэл зүйч томилон ажиллуулах бөгөөд эрүүл мэндийн байгууллага ажиллах нөхцөл, боломжоор хангана.

3.9. Эрх бүхий байгууллага нь гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ авч байсан байгууллагыг гэрч, хохирогчтой зөвшилцэн өөрчилж болно.

Дөрөв. Эрх бүхий байгууллагын хүлээх үүрэг

4.1. Эрх бүхий байгууллага нь гэрч, хохирогчид эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ:

4.1.1. гэрч, хохирогчийг эрүүл мэндийн байгууллагад хэвтүүлж, эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх тохиолдолд тэдний аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээг зөв тогтоож түүнд тохирсон хамгаалалтын арга хэмжээ авах;

4.1.2. хугацааны хувьд эрүүл мэндийн байгууллагын туслалцааг авах боломжгүй тохиолдолд гэрч, хохирогчид эрүүл мэндийн анхан шатны тусlamж, үйлчилгээг үзүүлэх, богино хугацаанд хамгийн ойр орших эрүүл мэндийн байгууллагад хүргэх;

4.1.3. биеийн байдал хүнд, амь нас нь тэнссэн гэрч, хохирогчийн гэр бүлийн гишүүнд энэ тухай яаралтай мэдэгдэх, уулзах нөхцөл боломжоор хангах;

4.2. өөрийн байгууллагын албан хаагчдад эрүүл мэндийн анхан шатны тусlamж, үйлчилгээ үзүүлэх дадал, чадвар олгох сургалтыг эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулах.

Тав. Гэрч, хохирогчийн хүлээх үүрэг

5.1. Гэрч, хохирогч нь эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд хамрагдах талаар дор дурдсан үүрэг хүлээнэ:

5.1.1. энэ журмын 3.1 дэх хэсэгт заасан тохиолдолд эрх бүхий байгууллагад мэдэгдэх;

5.1.2. эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтэнд биеийн зовиур, хууч өвчин, харшлын талаарх мэдээллийг үнэн зөв өгөх.

5.2. Гэрч, хохирогч нь хамгаалалтын арга хэмжээнд хамрагдахаас өмнө авч байсан эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг үргэлжлүүлэн авах, урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд хамрагдах бол энэ журмын гуравдугаар хэсэгт заасныг баримтална.

Зургаа. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний зардал

6.1. Эрх бүхий байгууллага нь дор дурдсан эрүүл мэндийн тусlamж үйлчилгээнээс бусад зардлыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21^3 дугаар зүйлийн $21^3.10$ дахь хэсэгт заасны дагуу Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас гаргуулж, буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ:

6.1.1. Эрүүл мэндийн тухай хуульд заасан улсын төсвөөс санхүүжих тусlamж, үйлчилгээ;

6.1.2. иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан иргэний эрүүл мэндийн даатгалаас санхүүжих тусlamж, үйлчилгээ;

6.1.3. энэ журмын 6.3 дахь хэсэгт заасан тусlamж, үйлчилгээ.

6.2. Эрүүл мэндийн байгууллага нь гэрч, хохирогчийн амь насыг аврах, эрүүл мэндэд учирсан ноцтой аюулыг нэн даруй арилгахад шаардагдах энэ журмын 6.1.1 - 6.1.3 дахь хэсэгт зааснаас бусад эрүүл мэндийн төлбөртэй тусlamж, үйлчилгээг өөрийн зардлаар үзүүлж, гарсан зардлыг эрх бүхий байгууллага гаргана.

6.3. Гэрч, хохирогч нь гэрч, хохирогчоор тогтоогдохоос өмнө авсан гэмтэл, бэртэл, бусад өвчний шалтгаанаар эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд хамрагдах, түүнчлэн урьд авч байсан эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг үргэлжлүүлэн авах болон эд, эрхтэний донор болох зардлаа өөрөө хариуцна.

Долоо. Бусад

7.1. Эрх бүхий байгууллага нь энэ журмыг зөрчсөн гэрч, хохирогчийн хамгаалалтын арга хэмжээг цуцлах, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд хамруулахад гарсан зардлыг нөхөн төлүүлэх асуудлыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.